



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 01 дүгээр сарын 10 өдөр

Дугаар 03

Хэрлэн сум

III ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 03 дугаар хуралдаан 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 13:00 цагт аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 75,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч Ш.Ёл даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Дашбалбар, Чулуунхороот суманд батлагдсан малын гоц халдварт цэцэг өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

*Мал эмнэлгийн газар*

2. Хорио цээрийн дэглэм тогтоох тухай аймгийн Засаг даргын захирамжийн төсөл танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа,

Дашбалбар, Чулуунхороот сумдын Засаг дарга,  
Онцгой комиссын дарга нарт:

1.1. Малын гоц халдварт хонины цэцэг өвчин батлагдсан Дашбалбар, Чулуунхороот сумдын сэжигтэй болон голомтын бүсэд үзлэг, тандалтын ажлыг зохион байгуулах талаар сумын Мал эмнэлгийн тасгуудад чиглэл өгч ажиллах,

1.2. Малын гоц халдварт хонины цэцэг өвчин батлагдсан Дашбалбар, Чулуунхороот сумдын сэжигтэй болон голомтын бүсэд малын дархлаажуулалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулах,

Дашбалбар, Чулуунхороот сумдын Засаг дарга,  
Онцгой комиссын дарга нарт:

1.3. Малын гоц халдварт хонины цэцэг өвчин батлагдсантай холбогдуулан малын шилжилт хөдөлгөөн, отроор нүүдэллэж буй малчин өрхүүдэд хяналт тавьж ажиллах,

1.4. Сэжигтэй болон голомтын бүсийг өргөн хүрээгээр тогтоож, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,

 / Ш.Ёл  
/ х/ч Б.Цогтбаяр

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,  
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Аюушмаа нарт:

2.1.Дашбалбар, Чулуунхороот суманд малын гоц халдварт хонины цэцэг өвчин батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” захирамжийн төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Аюушмаа-д:

2.2.Дашбалбар, Чулуунхороот суманд малын гоц халдварт хонины цэцэг өвчин батлагдсантай холбогдуулан сэрэмжлүүлэг, мэдээллийг албан бичгээр сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт хүргүүлэхийг тус тус үүрэг болгов.

ОРЛОГЧ ДАРГА

Ш.ЁЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР